



МОНГОЛ УЛС
ХЭНГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 24 өдөр

Дугаар А/96

Хэрлэн сум

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн
эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын
салбар комиссын бүрэлдэхүүнийг шинэчлэн
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, 60 дугаар зүйлийн 60.1.1, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2.2, 42 дугаар зүйлийн 42.1.1, Засгийн газрын 2021 оны 173 дугаар тогтоолоор батлагдсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын дүрэм”-ийн 2.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн хэмжээнд 0-16 насны хүүхдийг хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг тогтоох, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамруулах үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хэрэгжилтэд хяналт тавих зорилго бүхий салбар комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Нарийн бичгийн
дарга

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний асуудал
хариуцсан мэргэжилтэн

Гишүүд

Боловсролын газрын Биеийн тамир, спорт,
тэгш хамран сургалт хариуцсан арга зүйч
Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн
газрын Хүүхдийн асуудал хариуцсан ахлах
мэргэжилтэн

Л.Эрдэнэсүвд

Нэгдсэн эмнэлгийн Хүүхдийн их эмч

О.Намжилмаа

Нэгдсэн эмнэлгийн Мэдрэлийн их эмч

Д.Оюунчимэг

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг
эхчүүдийн холбооны тэргүүн

2.

2.Салбар комиссын үйл ажиллагааг тогтмолжуулж, чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахыг комиссын даргад үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2017 оны А/51 дугаар захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ